



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/236

Мандалговь

Э.Тогоохүү багшийг урамшуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "г", Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 318 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.6, аймгийн Засаг даргын 2017 оны А/251 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан "Урамшууллын жишиг тогтоох журам"-ын 3.3.3, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Говийн ирээдүй" цогцолбор сургуулийн монгол хэлний багш Э.Тогоохүү нь 2018-2019 оны хичээлийн жилийн Улсын төрөлжсөн олимпиадад, монгол хэл, бичгийн төрөлд гутгаар байр эзэлсэн тул урамшуулсугай.

Хоёр. Урамшуулалд шаардагдах 150000 (нэг зуун тавин мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

438190620